

# ECONOMIC **OUTLOOK** OF MONGOLIA 2025



# Удиртгал

Монгол улсын эдийн засгийн 2025 оны төлөв байдлын таамаглалын тайланг танилцуулж байна. Дэлхий дахиныг хамарсан цар тахал, цаг агаарын огцом өөрчлөлтөөс шалтгаалсан хөдөө аж ахуйд учирсан гарз хохирол, ОХУ-ын Украин улс руу хийсэн дайралт болон бусад геополитикийн тулгамдсан асуудал, зөрчилдөөн гэх мэт олон асуудал, хүндрэлтэй байсан ч Монгол улсын эдийн засаг сүүлийн 5 жилийн турш тогтвортой бөгөөд хурдацтай өсөн, 2024 онд дэлхийн хамгийн хурдан өсөлттэй эдийн засагтай улс орнуудын нэг болсон билээ.

- Энэхүү өсөлтийг цаашид хадгалж чадах эсэх нь эдийн засгийг амжилттай солонгоруулж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийг дэмжих, уул уурхайн салбарт орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг хадгалахын хажуугаар эдийн засгийн бусад салбаруудад хөрөнгө оруулалт татах, газрын баялгийн орлогыг оновчтой хадгалан зарцуулж, нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зэргээс шалтгаална.

Инфляц Монголбанкны тогтоосон зорилтот түвшин буюу  $\pm 6$  хувьд хүрэн буурж, бодлогын хүүг шат дараатайгаар 3.0 нэгж хувиар буулган 10.0 хувьд хүргэв. Гадаад валютын улсын нөөц 2020 онд түүхэн доод хэмжээнд хүрээд байснаасаа эргэн сэргэж, 5.0 тэрбум ам.доллар даван, төгрөгийн ханш чангарлаа.

Энэхүү тайланд бид Монгол улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хэтийн төлөвийн таамаглалын тухай тодорхой ойлголт авч, хөрөнгө оруулалтын боломжуудыг ашиглахад туслах мэдээллийг доорх 5 бүлэгт танилцууллаа:

- Монголын эдийн засгийн сүүлийн хугацааны өсөлт, хөгжил
- Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төлөвийн таамаглал болон зах зээлд үзүүлэх нөлөө
- Голчлох үзүүлэлтүүд
  - Гадаад валютын улсын нөөц
  - Нүүрсний зах зээл
  - Инфляц
- Мөнгөний болон төсвийн бодлогын зах зээлд үзүүлэх нөлөө
- 2025 онд хөрөнгө оруулалтын зөвлөгөө

# Гарчиг

01

Монголын эдийн  
засгийн сүүлийн  
хугацааны өсөлт, хөгжил

03

Голчлох үзүүлэлтүүд

Гадаад валютын улсын нөөц  
Нүүрсний зах зээл  
Инфляц

05

2025 онд хөрөнгө  
оруулалтын зөвлөгөө

02

Макро эдийн засгийн  
үзүүлэлтүүдийн төлөвийн  
таамаглал болон зах  
зээлд үзүүлэх нөлөө

04

Мөнгөний болон  
төсвийн бодлогын зах  
зээлд үзүүлэх нөлөө

# 1-р ХЭСЭГ

01

ДНБ-ийн өсөлт 7.4 хувьд хүрч, Монгол улс дэлхийн хамгийн хурдацтай өсөж буй орнуудын нэг болов. Ковид-19 цар тахлын хохирлыг амжилттай даван гарч, эдийн засаг хурдацтай сэргэж эхлэв. 2023 онд тохиосон зудын улмаас 2 сая гаруй мал үрэгдэж, хөдөө аж ахуйн салбарт учирсан ихээхэн хохирол эрдэс баялгийн үнийн өсөлтийг даган өсөж байсан эдийн засгийн өсөлтийг бага зэрэг удаашруулсан байна.

02

Инфляц Монголбанкны зорилтот түвшин болох  $\pm 6$  хувийн интервалд хүрч буурав. Гол нэрийн бараануудын үнийн өсөлт харьцангуй тогтвортой байсан бол боловсролын салбарын үнийн өсөлт инфляцын өсөлтөд голчлон нөлөөлсөн байна.

03

Өрийн оновчтой удирдлагын бодлого болон амжилттай дахин санхүүжилтүүдийн үр дүнд төсөвт үзүүлэх өрийн дарамт мэдэгдэхүйц буурав.

04

Сүүлийн 5 жилд экспортын хэмжээ 2 дахин нэмэгдэж, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 11.8 тэрбум ам.долларт хүрсний 87.4 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Мөн 2024 оны 3 дугаар улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл ойролцоогоор 3.2 тэрбум ам.долларт хүрсэн байна.


05

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал 2023 онд өнгөрсөн онтой харьцуулахад 40 хувиар буурсан байна. Харин 2024 оны 2 дугаар улирлын байдлаар хөрөнгө оруулалт эргэн сэргэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33 хувиар ихэссэн үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгө оруулалтын ойролцоогоор 80-90 хувь нь зориулагддаг.

## 2022 онд эдийн засаг 5.0 хувь өсөж байсан бол 2023 онд улам эрчимжиж, 7.4 хувийн өсөлтийг үзүүлжээ.

2020 онд 4.6 хувиар агшаад байсан эдийн засаг сүүлийн 3 жил тасралтгүй өссөн байна. 2021 онд цар тахлын улмаас БНХАУ хилийн хязгаарлалт тавиж, гадаад худалдааны үйл явцад хүндрэл тулгарсныг үл харгалзан 1.6 хувь өсжээ. Санхүү болон даатгалын үйл ажиллагаа, мэдээлэл технологи харилцаа холбооны салбарууд 2021 онд тус тус 9.7 болон 20.7 хувиар өссөн нь энэхүү өсөлтийн гол хүчин зүйл болсон байна. Өнгөрсөн оны өсөлтийн хувьд эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн өсөлт, Оюутолгойн далд уурхайн үйл ажиллагаа эхэлсэн болон БНХАУ-ын нүүрсний эрэлт нэмэгдсэн зэрэг нь голчлон нөлөөлжээ.


2023 оны ДНБ-ийн 7.4 хувийн өсөлтийн 2.6 нэгж хувийг уул уурхайн салбар, 1.8 нэгж хувийг ачаа тээвэр болон хадгалалтын салбар тус тус бүрдүүлсэн байна. Уул уурхайн салбар хөгжихийн хэрээр хамааралтай салбарууд болох тээвэр болон бусад үйлчилгээний үйл ажиллагаанууд идэвхжиж эхэлжээ. Харин өнгөрсөн онд тохиосон байгалийн аюулт үзэгдэл зудын улмаас ДНБ-ийн 10 орчим хувийг эзэлдэг аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 8.9 хувиар бууран, эдийн засгийн өсөлтийг 1.3 хувиар сааруулсан байна.



Хүснэгт 1. ДНБ-ийн өсөлт, салбараар. Уул уурхай болон олборлолт өсөлтөд хамгийн нөлөөтэй салбар хэвээр байна.

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

**2023 оны ДНБ-ийн өсөлтөд салбаруудын үзүүлэх нөлөө**



2023 оны ДНБ-ийн өсөлтөд салбаруудын үзүүлэх нөлөө. Зудын улмаас учирсан хохирлын нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар өсөлтийг удаашруулсан байна.

## Инфляц буурч, Монголбанкны зорилтот интервалд орсон байна. Монголбанкны зүгээс мөнгөний бодлогоо сулруулан 2024 онд бодлогын хүүг 3 нэгж хувиар бууруулав.

Ковид-19 цар тахлын улмаас олон улсын, тэр дундаа хөгжиж буй орнуудын инфляц өсөж, эдийн засаг уналтад орж байсан. Монгол улсын хувьд тухайн үед 16.1 хувьд хүрж байсан инфляц 2022 оны дунд үеэс эхлэн тогтвортой буурж, 2023 оны 11 дүгээр сар гэхэд Монголбанкнаас тогтоосон зорилтот интервал буюу  $6 \pm 2$  хувьд хүржээ. Энэхүү бууралт 2024 оны 6 дугаар сар буюу парламентын сонгуулийн үед 5.1 хувьд

хүртэл үргэлжлэн, сонгуулийн дараагаас төрийн албан хаагчдын цалин болон тэтгэврийн нэмэгдэлтэйгээр холбоотойгоор дотоод эрэлтийн өсөлтийг даган инфляцын дүн мөн өсөж эхэлжээ. 2024 оны 10 дугаар сарын байдлаар инфляц 7.0 хувьд хүрсэн байна.

2022 оны 6 дугаар сартай харьцуулахад ерөнхий хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 17.3 хувиар өсөхөд

хүнсний бүтээгдэхүүн болон согтууруулах ундааны үнийн индекс 20.1 хувийн өсөлт голчлон нөлөөлжээ. Харин өнгөрсөн жилийн хувьд 8-аас 9 дүгээр сард ерөнхий ХҮИ харьцангуй өссөн нь боловсролын салбарын үнийн индекс 16 нэгжээр буюу хэрэглээний

сагсан дахь аль ч бүтээгдэхүүнээс илүү огцом өсөлттэй холбоотой. Дундаж орлоготой айл өрхийн хувьд нэг оюутны сард ногдох сургалтын төлбөрийн зардал нь тухайн өрхийн сарын орлогын 20 гаруй хувийг эзлэхээр дүнтэй байгаа юм.



Хүснэгт 3. Баруун гар талд жилийн өөрчлөлт. Гол инфляц харьцангуй тогтвортой байгаа бол хүнсний бүтээгдэхүүн болон согтууруулах бус ундааны болон боловсролын үнийн өсөлт инфляцын өсөлтөд голчлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж, Монголбанк, Statistical bulletin 2024-09

## Төвийн тэнцэл сүүлийн 5 жилд анх удаа эерэг гарч, 785.9 тэрбум төгрөгийн ашигт хүржээ. Засгийн газрын нийт орлого өнгөрсөн жилээс 31.7 хувиар өссөн бол зарлага 23.7 хувиар өссөн байна.

2023 онд Монгол улсын төсвийн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан үзүүлэлттэй байна. 2023 оноос өмнөх 4 жилд Монгол улсын төсвийн тэнцэл алдагдалтай гарж байсан бөгөөд 2020 онд алдагдал 4.5 их наяд төгрөгт хүрж, ДНБ-ийн 12 хувьтай тэнцэж байжээ. Уул уурхайн салбарын орлогын өсөлтийг даган нийгмийн халамж болон бусад төсвийн зардлууд нэмэгдэж ирсэн. 2024 оны 8 сард төсвийн тодотгол хийн зардлын хэмжээг ихэсгэсэн байна. 2023 онд засгийн газрын зардлын хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 23.7 хувиар ихэссэн бөгөөд бараа үйлчилгээний болон хөрөнгийн зардлын өсөлт нь тус өсөлтийн 7 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Тус хугацаанд хүүгийн зардал 42 хувиар өссөн бол тэтгэврийн хэмжээг нэмсэнтэй холбоотойгоор нийгмийн даатгалын зарлага 53 хувиар ихэссэн байна. 2020 онд 10 ажилтан тутамд 4 тэтгэврийн иргэн ноогдож байсан бол улсын дундаж наслалт

2000 онтой харьцуулахад 8.3 жилээр ихэссэнтэй холбоотойгоор 2030 онд уг тоо 7 болж нэмэгдэх төлөвтэй байна. Үүнээс гадна Эрдэнэс Тавантолгойн ногдол ашгийн зардал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өсгөсөн зэрэгтэй холбоотойгоор урсгал шилжүүлэг 12.7 хувиар өссөн байна. Мөн дотоодын хөрөнгө оруулалтын зардал 36 хувиар өсжээ. Төсвийн зардал ийнхүү ихээхэн хэмжээгээр өссөн ч төсвийн орлого сүүлийн 5 жил бүр дунджаар 31.7 хувиар нэмэгдсэнээр 2023 онд төсвийн тэнцэл алдагдалгүй гарсан байна. Төсвийн орлогын өсөлтийн 10.1 хувийг орлогын албан татвар бүрдүүлсэн байна. Үүнтэй хамтаар нийгмийн даатгалын орлого болон нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад татварын өсөлт төсвийн орлогыг 32.5 хувиар өсгөх боломжтой болгосон ч тогтворжуулалтын сангийн зарлагатай

холбоотойгоор орлогын хэмжээ бага зэрэг буурсан байна.

## Өрийн удирдлагын амжилттай төслүүдийн хүрээнд засгийн газрын нийт өрийг ДНБ-ийн 47 хувьтай тэнцэх хэмжээнд бууруулсан байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд засгийн газрын нэгдсэн өрийн үлдэгдэл дүнгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 60%-аас хэтрэхгүй байна гэж заасан байдаг. 2022-2024 оны хооронд хэрэгжүүлсэн өрийн удирдлагын амжилттай бодлогын хүрээнд Сенчюри 1, 2, 3 хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол улс харьцангуй бага хүүтэй санхүүжилт олон улсаас татан төвлөрүүлж, эргэн төлөлтийн хугацаа нь хэтрээд байсан Хуралдай бондыг дахин санхүүжүүлэх, 2024 оны 3 сард хугацаа нь дуусах

бондын зарим хэсгийг эргүүлэн худалдан авах боломжтой болсон. Ингэснээрээ 2023 оны эцэс гэхэд өрийн ДНБ-д эзлэх харьцааг 47 орчим хувьд хүртэл буулгасан байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар засгийн газрын нийт өр 29.7 их наяд төгрөгийн дүнтэй байна. Засгийн газрын бондын дундаж өгөөж 6.7 хувь байгаа бол Засгийн газрын нийт өрийн 90 гаруй хувийг гадаад өр, 0.5 хувийг дотоод өр эзэлж байгаа бол 2024 оны эхний хагас гэхэд барих-шилжүүлэх концессын дүнг 0 болгон буурж, засгийн газрын баталгаа бага зэрэг өссөн дүнтэй байна.



Хүснэгт 4. Засгийн газрын өр, өрийн хэрэгслээр, баруун гар талд өрийн зардал.

Source: Ministry of Finance, Debt bulletin 2024

## Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтворжив. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар төгрөгийн ханш оны эхэнтэй харьцуулахад 0.8 хувиар чангарсан байна.


Цар тахалтай холбоотойгоор БНХАУ хилийн хязгаарлалт хийсэн, Орос Украины дайны улмаас импортын дизель болон автобензины үнэ өссөн зэргээс шалтгаалан төгрөгийн ханш 2022 онд 20 орчим хувиар суларсан. 2023 оны 3 дугаар сард төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,524.98 хүртлээ өссөний дараагаас БНХАУ хилийн хоригоо цуцалж, импортын үнэ энгийн түвшиндээ очсонтой

холбоотойгоор сүүлийн 6 улирлын турш сард дунджаар 0.3 хувиар чангарчээ.

2024 оны 8 дугаар сарын байдлаар Монгол улсын гадаад валютын албан нөөц 4.7 тэрбум долларт хүрж, өнгөрсөн оны мөн үеэс 23.8 хувиар өссөн дүнтэй байна.

2023 онд төсвийн тэнцэл ашигтай гарж, өрийн удирдлагын оновчтой менежментийн хөтөлбөрүүдийн хүрээнд засгийн газрын өрийн дарамт харьцангуй багассан зэрэг нь энэхүү өсөлтөд нөлөөлсөн байна. 2023 оны эцсээр Монголбанк БНХАУ-тай хийсэн валютын своп

арилжааны хэлцлийн 6 тэрбум юанийг эргүүлэн төлсөн байна. Сүүлийн 3 жилд улсын гадаад валютын албан нөөцийн жил тутмын жигнэсэн дундаж нийлмэл өсөлт нь 18.6 хувьтай тэнцэж байсан байна.



Хүснэгт 5. Баруун гар талд валютын ханш, REER болон NEER индекс зүүн гар талд

Source: Bank of Mongolia, Statistical bulletin 2024-09

## Гадаад худалдааны эргэлт 2023 онд ДНБ-ийн 28.4 хувьтай тэнцэж байгаа нь сүүлийн 10 жилд гараагүй сайн үзүүлэлт юм.

2024 оны эхний хагасын байдлаар Монгол улсын гадаад худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үеэс 12.2 хувиар өсөн 13.2 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна. Уул уурхайн бүтээгдэхүүний өсөлтөөс улбаатайгаар экспортын дүн өнгөрсөн оны мөн үеэс 4.4 хувиар өсөн, гадаад худалдааны тэнцлийг 2.5 тэрбум ам.долларт хүргэжээ. Нийт экспортын 90 орчим хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд тус салбарын экспортын 6.6 хувийн өсөлтөд зэсийн баяжмалын экспорт 9.4 хувь, нүүрсний экспорт 7.5 хувиар тус тус өссөн ч голчлон нөлөөлсөн байна.

Импортын хувьд тайлант улиралд өнгөрсөн оны мөн үеэс 25.8 хувиар өсөн 5.4 тэрбум ам.долларт хүржээ. Монгол улс дизель түлш болон автобензины хэрэглээгээ бүхлээр нь импортоор хангадаг бөгөөд түлшний импорт нь нийт импортын ойролцоогоор 20 хувийг эзэлдэг. Өнгөрсөн онд тулгараад байсан геополитикийн асуудлын улмаас Орос улсаас импортлох түлшний үнэ өссөн нь импортын нийт зардал нэмэгдэх гол хүчин зүйлүүдийн нэг болжээ. Машин тоног төхөөрөмж болон цахилгаан барааны импорт нь мөн тус тус 45.8 болон 36.3 хувиар өссөн нь мөн тус өсөлтөд нөлөөлсөн байна.

## Гадаадын хөрөнгө оруулалтын шууд урсгалын ихэнх хувь нь уул уурхайн салбар луу чиглэсэн байна.

Сүүлийн 5 жилд Монгол улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын жигнэсэн дундаж нийлмэл хүү 5.3 хувь байсан байна. Энэхүү урсгалын дийлэнх хувь нь уул уурхайн салбарт

ордог бөгөөд 2023 онд цар тахлын улмаас засгийн газрын өр өсөж, эдийн засгийн тогтворгүй байдал



үүссэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын дүн бага зэрэг буурч байсан юм.

2022 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал өмнөх оноос 26.0 хувиар ихсэн 3.4 тэрбум доллартой тэнцжээ. Харин 2023 оны эхэн үед Оюутолгойн уурхайн далд уурхайн үйл ажиллагаа амжилттай эхэлж, бүтээн байгуулалт дууссанаар тус төслийн хөрөнгө оруулалт буурсантай холбоотойгоор нийт хөрөнгө оруулалтын урсгалын хэмжээ багасжээ. Гэсэн хэдий ч 2023 онд Монгол улс 650 сая ам.доллар болон 350 сая ам.долларын хэмжээтэй бондыг гарган, санхүүжилтээ амжилттай татан төвлөрүүлснээс гадаадын хөрөнгө оруулагчдын Монгол улсад хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж байгааг харж болно.

2023 оны байдлаар уул уурхайн бус салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт ДНБ-ийн ердөө 6.9 хувьтай тэнцэж байгаа нь эдийн засгийн нэг салбараас хэт хамааралтай байгааг харуулж байна. Уул уурхайгаас бусад салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг амжилттай татах нь эдийн засгийн хэт төвлөрлийг бууруулахад гол түлхэц болно. Одоогийн байдлаар Монгол улс хөрөнгө оруулагчдыг татах үүднээс татварын таатай нөхцөлийг бүрдүүлэх, хууль эрхзүйн орчныг тодорхой, нээлттэй байлгах тал дээр анхаарах шаардлагатай. Одоогийн байдлаар гадаадын хөрөнгө оруулагчид газар болон үл хөдлөх хөрөнгө эзэмшихээс бусдаар хуулийн этгээд байгуулах, шилжүүлэх болон өмчлөхөд дотоодын хөрөнгө оруулагчидтай ижил эрх үүргийг хүлээж байна.

## 2-р ХЭСЭГ

01

ДНБ-ын өсөлт нь 2025-2027 онд тогтвортой буюу 5 хувь орчимд байна гэж таамаглаж байна. Энэхүү төсөөлөл нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон зах зээлийн үнийн хөдөлгөөнөөс ихээхэн хамааралтай үзүүлэлт юм.

02

Шинэчлэгдэн байгуулагдсан засгийн газрын 14 мега төслийн зардлын хүрээнд төсвийн зарлага харьцангуй ихсэж, газрын баялгийн орлого дээр тулгуурлан өсөх төсвийн орлоготой тэнцэх төлөвтэй байна.

03

2025 онд гадаад худалдааны эргэлт 36.1 тэрбум доллар, гадаад худалдааны тэнцэл 5.1 тэрбум доллар байна гэж тооцоолсон. 2023-2027 онд экспортын жигнэсэн дундаж нийлмэл хүү нь 13.2 хувь буюу өнгөрсөн 5 жилийн 15.1 хувийн өсөлтийн хувиас бага зэрэг буурсан дүнтэй байхаар байна. Импортын хувьд тус үзүүлэлт нь ойролцоогоор 15 хувь байх бөгөөд машин, тоног төхөөрөмж болон цахилгаан барааны импортын өсөлт энэхүү өсөлтөд голчлон нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

## ДНБ-ийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн таамаглалууд

Монгол улс нь экспортын 80 орчим хувийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзэлдэг, эдийн засаг нь газрын баялгаас ихээхэн хамааралтай улсуудын нэг юм. Манай улстай ижил хөгжиж буй эдийн засагтай улсуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл нь уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон үнийн таамаглал болон газрын баялгийн орлогыг үр дүнтэй зарцуулж чадах байгаа эсэхтэй шууд холбоотой байдаг. Иймээс бидний ашигласан DIGNAR-19 моделийн үндсэн 14 үзүүлэлтүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний, тэр дундаа зэс, нүүрс болон алтны үйлдвэрлэлийн хэмжээ, эдгээрийн үнийн таамаглал, засгийн газрын хэрэглээ, хөрөнгө оруулалт болон нийт орлогын төсөөллүүдийг орсон. Сүүлийн жилүүдэд хурдацтай өсөөд байгаа эдийн засгийн өсөлтийг хадгалж чадах эсэх нь газрын баялгийн орлогыг үр ашигтай зарцуулж чадах эсэхээс хамаардаг.

2024 оны эхэн үед Монгол улсын засгийн газраас “Ирээдүйн өв сан”, “Хөгжлийн сан” болон “Хуримтлалын сан” гэсэн гурван төрөлжсөн сангаас бүрдэх Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг сангаар дамжуулан уул уурхайн үр өгөөжийг иргэдэд хүртээмжтэй байлгах, хадгалах болон үр ашигтай зарцуулах үйл ажиллагааг явуулах юм.

**Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн таамаглал:** Зэсийн үйлдвэрлэл 2025 онд бага зэрэг бууран, цаашлаад жилд 5 орчим хувиар өсөх төлөвтэй байна. Оюутолгойн далд уурхайн олборлолт энэхүү өсөлтөд гол нөлөө үзүүлнэ. Зэсийн үнэ тогтвортой өсөн, 2027 он гэхэд нэг тонн нь 10.0 мянган ам.долларыг давах төлөвтэй байна. Нүүрсний үйлдвэрлэлийн хувьд ирэх онд 2024 оныхтой ижил түвшинтэй байх бөгөөд үнэ нь мөн адил тогтворжин өөрчлөлт багатай байна гэж тооцоолсон.

**Засгийн газрын хөрөнгө оруулалтын таамаглал:** Засгийн газрын хөрөнгө оруулалт нь 2024 онд өмнөх онуудтай харьцангуй өссөн бөгөөд ирэх 3 жилд жил бүр дунджаар 4 хувь өсөх төлөвтэй байна.

**Татварын хувийн таамаглал:** Засгийн газрын ирэх оны төсвийн зардлын төслийн дагуу орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн татварын хувийг өөрчлөгдөхгүй гэж таамагласан.


**Засгийн газрын хэрэглээний эзлэх хувь:** Засгийн газрын хэрэглээний ирэх 3 жилийн жигнэсэн дундаж нийлмэл өсөлт ойролцоогоор 8.2 хувь байх буюу 2027 оны эцэс гэхэд 15.8 тэрбум ам.долларт хүрж, ДНБ-ийн 14.6 хувьтай тэнцэх

таамаглалтай байна. 2023 оны байдлаар олон улсын засгийн газрын хэрэглээний ДНБ-тай харьцуулсан харьцаа ойролцоогоор 16.5 хувь байсан бол Зүүн Ази болон Номхон далайн орнуудын улсуудын хувьд тус үзүүлэлт нь 15.3 хувь, дундаж орлоготой орнуудын хувьд 14.6 хувьтай байна.

**Засгийн газрын шилжүүлгийн таамаглал:** Ковид-19 цар тахлын үед нийгмийн халамжийн бодлогын хүрээнд татаас, шилжүүлгийн хэмжээ огцом өссөнтэй холбогдуулан 2020-2023 онд засгийн газрын шилжүүлгийн хэмжээ 2 дахин өссөн дүнтэй байна. Тухайн үед эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг идэвхжүүлэх зорилгоор Монгол улсын иргэн бүрд нэг удаагийн 300 мянган төгрөгийн тусламж олгосноос гадна улс орон даяар хамарсан албан журмын ковидын тест, өвчилсөн хүмүүст олгосон тусламж зэрэг нь засгийн газрын шилжүүлгийг ихсэхэд гол нөлөө үзүүлсэн. Бид төсөөлөлдөө дээрхтэй ижил төстэй огцом өөрчлөлт ойрын хугацаанд дахин тулгарахгүй гэж таамаглан, ирэх гурван жилд засгийн газрын шилжүүлгийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа жил бүр ялимгүй багасан 2027 оны сүүл үе гэхэд 12.7 хувь хүрнэ гэж тооцоолсон.

## ДНБ-ийн өсөлт 2025 онд бага зэрэг бууран, 2026 болон 2027 онд тогтворжих төлөвтэй байна.

Ирэх гурван жилийн уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн таатай нөхцөл байдал Монгол улсын уул уурхайн салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Бидний тооцооллоор энэхүү өсөлт нь 2022-2023 оны огцом өсөлтөөс харьцангуй бага хэдий ч тогтвортой байх бөгөөд 2024 онд 6.8 хувь, 2025-2027 онд 5.2-5.3 хувь байна гэж таамаглаж байна.




Хүснэгт 6. ДНБ-ийн өсөлтийн сценариуд

Эрдэс бүтээгдэхүүний үнийн индексээс бусад нөлөөлөгч хүчин зүйлүүдийг тогтмол байна гэж үзвэл тус индекс нь ДНБ-д хэрхэн нөлөөлөх хамаарлыг шинжлэхийн тулд бид 3 сценарийн ирэх гурван жилийн төсөөллийн тооцооллыг хийсэн. Эдгээр нь - тус индексийг 1) 2024 оны 2 дугаар улиралтай ижил түвшинд, 2) Жилд 5 хувиар ихсэх, 3) Жилд 5 хувиар багасах нөхцөлүүд байна.

Эрдэс бүтээгдэхүүний импортын нийт импортод эзлэх хувь 25 орчим буюу экспортын 80-90 хувийн харьцаанаас харьцангуй бага байдаг хэдий ч

Эх сурвалж: Шинжээчийн таамаг

Монгол улсын хэрэглээний үнийн индексийг хөдөлгөгч гол хүчин зүйлүүдийн нэг болох дизель болон автобензины хувьд импортоос бүрэн хамааралтай байдаг. Иймээс үнийн индекс тогтмол байх нь Монгол улсын эдийн засагт жил бүр 5 хувь өссөнөөс илүү эерэг нөлөөтэй байхаар байна. Тус индекс тогтмол байх нөхцөлд ДНБ-ийн өсөлт 2027 он гэхэд 9.7 хувь буюу бидний үндсэн 5.3 хувийн төсөөллөөс үнэмлэхүй их байхаар байгаа юм. Харин жилд 5 хувиар буурах нөхцөлд ДНБ-ийн өсөлт 3.8 хувь болж агших магадлалтай байна.



Хүснэгт 7. Экспортын үнийн индекс тулгуурласан ДНБ-ийн өсөлтийн хувийн төсөөлөл

Эх сурвалж: Шинжээчийн таамаг

## Экспорт жилд дунджаар 5.2 хувиар өсөн, 2027 онд 19 тэрбум доллар орчимд хүрэх төлөвтэй байна.

Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ ирэх 3 жилд харьцангуй тогтвортой буюу жилд дунджаар 5 хувийн бууралтаас 8 хувийн өсөлтийн хооронд хэлбэлзэх төлөвтэй байна. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр гэх мэт бүтээгдэхүүнүүд үнийн хувьд тогтвортой байх хэдий ч Монгол улсын үйлдвэрлэл нэмэгдэн, түүнийгээ дагаад экспортын орлого мөн ихсэх төлөвтэй байна. Сүүлийн 3 жилд гэхэд нүүрсний үйлдвэрлэл гурав дахин нэмэгдсэн бөгөөд ирэх жилүүдэд ийм хурдацтай өсөлтийг хадгалах хүндрэлтэй ч, одоогийн өссөн хэмжээнээс буулгах хүчин зүйл байхгүй байгаа юм. Шинэчлэгдэн байгуулагдсан хамтарсан засгийн газрын зүгээс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 14 мега төсөлд уул уурхайн салбарыг хөгжүүлж, эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн өсөлтийн циклийг үр өгөөжтэй ашиглан экспортын орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх хэд хэдэн төсөл орсон байгаа нь:

- Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнансан төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих
- Тавантолгойн 450 мвт-ын дулааны цахилгаан станцыг барих
- Зэс боловсруулах болон гангийн үйлдвэрлэлийн цогцолборыг ашиглалтад оруулах зэрэг байна.

2025 онд дээрх 14 мега төслөөс 5 нь хэрэгжиж эхлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд хилийн боомтуудын сайжирсан дэд бүтцийн тусламжтайгаар гадаад худалдааны эргэлт нэмэгдэн, бидний тооцооллоор экспортын хэмжээ

2027 он гэхэд 18.3 тэрбум ам.доллар хүрэх төлөвтэй байна.




Хүснэгт 8. Экспортын төсөөлөл

2024 оны гуравдугаар улирлын байдлаар зэсийн үйлдвэрлэл 2022 оны мөн үеийнхээс 45 хувиар ихэссэн байгаа нь энэ хугацаанд Оюутолгойн далд уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотой. Тус уурхайн олборлолтын бүтээмж нь 2028-2032 онд хамгийн дээд түвшиндээ хүрэх төлөвлөгөөтэй байна. Үүнтэйгээр холбоотойгоор ирэх гурван жилд зэсийн үйлдвэрлэл өмнөх онуудтай харьцуулахад бага зэрэг удааширсан буюу жилд 5 орчим хувиар өсөн, 2027 онд гэхэд ойролцоогоор жилд 1.9 сая тонн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ гэж таамагласан. Төмрийн хүдрийн үнэ бага зэрэг бууран, үйлдвэрлэл ихэссэнээр экспортын орлого тогтвортой байх төлөвтэй байна. 2021 онд 307 доллар хүрж байснаасаа хойш төмрийн хүдрийн үнэ 2024 оны гуравдугаар улирал гэхэд тал хүртлээ буурсан бөгөөд ирэх гурван жилд ч жилд дунджаар 4 хувиар буурахаар байна.


2023 онд уул уурхайн салбар нь нийт ДНБ-ийн 25 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 78 хувь, экспортын 87 хувийг бүрдүүлсэн байна. Монгол улсын эдийн засгийн уул уурхайн салбараас хамаарах хамаарал сүүлийн жилүүдэд улам ихэссээр байна. Өнгөрсөн онуудад эрдэс баялгийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өсөж, Оюутолгойн далд уурхайн ашиглалтыг эхлүүлсэн болон БНХАУ-ын нүүрсний эрэлт ихэссэн зэргээс шалтгаалан эдийн засаг хурдацтай өсөж байсан ч нэг салбараас хэт хамааралтай байгаа энэ байдал нь эдийн засгийг гадаад хүчин зүйлийн нөлөөнд хэт савлах эрсдэлд оруулж байна.

Сүүлийн 5 жилд Монгол улсын гадаад худалдааны эргэлтийн жилийн нийлмэл өсөлт 15.1 хувь байсан бол ирэх 2023-2027 онд уг өсөлт 14.3 хувьд хадгалагдан, 2027 онд нийт гадаад худалдааны эргэлт 41.5 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.




Хүснэгт 9. Импортын төсөөлөл

Эх сурвалж: Шинжээчийн таамаг



Хүснэгт 10. Гадаад худалдааны төсөөлөл


Эх сурвалж: Шинжээчийн таамаг



Монгол улсын эрдэс баялгийн экспортын гол бүтээгдэхүүнүүдэд зэсийн хүдэр ба баяжмал, нүүрс болон төмрийн хүдэр зэрэг багтдаг. Тус бүтээгдэхүүнүүдийн ирэх 3 жилийн үнийн хувьд:

- 2027 оны эцэс гэхэд нэг тонн зэсийн үнэ 10 мянган ам.доллар хүрэх төлөвтэй.
- Нүүрсний үнэ 2026 он хүртэл 150 ам.доллар хүртэл өсөн, түүнээс хойш үнэ тогтворжих төлөвтэй.
- Төмрийн хүдрийн үнэ улиралд 3.6 хувиар унах төлөвтэй.

**Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ**




Монгол улсын ДНБ-ийн ойролцоогоор 10 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлдэг бөгөөд нийт ажиллах хүчний дөрөвний нэг орчим хэсэг нь тус салбарт ажилладаг. Гэтэл энэ салбар нь цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай, байгалийн онц ноцтой үзэгдэл тохиолдох үед эрсдэлээс сэргийлэх бодлого хангалтгүйгээс эдийн засагт ихээхэн хохирол учруулах магадлалтай салбар юм. 2023 оны өвөл тохиосон зудын гамшгаас үүссэн хохирол гэхэд тус онд эдийн засгийн өсөлтийг 1.3 нэгж хувиар бууруулсан үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч түүхэн үзүүлэлтээс харахад Монгол улсын зудын давтамж ойролцоогоор 10 жилд нэг удаа байдаг тул энэ хугацаанд эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах боломжтой.

**Цаг агаарын аюултай үзэгдэл**

## Тулгарч болзошгүй эрсдэлүүд

**Эрчим хүчний үйлдвэрлэл**

Монгол улсын ДНБ-ийн ойролцоогоор 10 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлдэг бөгөөд нийт ажиллах хүчний дөрөвний нэг орчим хэсэг нь тус салбарт ажилладаг. Гэтэл энэ салбар нь цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай, байгалийн онц ноцтой үзэгдэл тохиолдох үед эрсдэлээс сэргийлэх бодлого хангалтгүйгээс эдийн засагт ихээхэн хохирол учруулах магадлалтай салбар юм. 2023 оны өвөл тохиосон зудын гамшгаас үүссэн хохирол гэхэд тус онд эдийн засгийн өсөлтийг 1.3 нэгж хувиар бууруулсан үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч түүхэн үзүүлэлтээс харахад Монгол улсын зудын давтамж ойролцоогоор 10 жилд нэг удаа байдаг тул энэ хугацаанд эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах боломжтой.



**БНХАУ-ын үйлдвэрлэлийн индекс**

2024 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол улсын нийт экспортын 60 орчим хувийг нүүрсний экспорт бүрдүүлж байна. Харин нүүрсний экспортын ойролцоогоор 90 хувийг БНХАУ хүлээн авдаг. Иймээс Монгол улсын эдийн засгийн өсөлтөд БНХАУ-ын манай улсаас авах нүүрсний эрэлтийн хэмжээ чухал нөлөөтэй байдаг.



## Монголын макро-эдийн засгийн үзүүлэлтүүдийн таамаглал (Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК)

Макро-эдийн засгийн үзүүлэлтүүд	2024	2025	2026	2027
1 ДНБ өсөлт	6.8%	5.2%	5.2%	5.3%
2 Засгийн газрын хөрөнгө оруулалт, их наяд төгрөг	3.8	4.0	4.3	4.5
Засгийн газрын хөрөнгө оруулалт/ДНБ	4.9%	4.6%	4.4%	4.2%
3 Засгийн газрын хэрэглээ, их наяд төгрөг	10.8	12.5	14.2	15.8
Засгийн газрын хэрэглээ/ДНБ	13.8%	14.2%	14.5%	14.6%
4 Засгийн газрын зарцуулалт, их наяд төгрөг	11.8	12.5	13.2	13.8
Засгийн газрын зарцуулалт /ДНБ	15.0%	14.2%	13.5%	12.7%
6 Экспорт, тэрбум ам.доллар	16.7	20.2	21.7	23.3
7 Импорт, тэрбум ам.доллар	12.4	16.1	17.2	18.2
8 Гадаад худалдааны тэнцэл, тэрбум ам.доллар	4.3	4.0	4.4	5.1
Гадаад худалдааны тэнцэл /ДНБ	18.5%	14.5%	14.2%	14.3%
9 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	61.9%	63.2%	64.1%	64.8%

## Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индикаторууд

Бүтээгдэхүүний үйлдвэрлэл	2024	2025	2026	2027
1 Нүүрсний үйлдвэрлэл, килотон	84,014.8	80,517.1	80,601.3	82,318.2
Нүүрсний үнэ, ам.доллар*	250.0	228.0	206.5	212.0
2 Зэсийн баяжмал үйлдвэрлэл, килотон	1,618.9	1,656.8	1,779.1	1,918.2
Зэсийн баяжмал үнэ, ам.доллар*	9,331.4	9,856.0	10,034.1	10,109.0
3 Төмрийн хүдрийн үйлдвэрлэл, килотон	5,951.7	5,563.9	6,800.3	8,311.3
Төмрийн хүдрийн баяжмал үнэ, ам.доллар*	109.6	102.4	96.9	92.9
4 Алтны үйлдвэрлэл, тон	13.5	16.1	16.0	16.0
Алтны үнэ, ам.доллар*	2,423.9	2,821.8	2,941.3	3,059.9

\*Bloomberg-ийн шинжээчдийн тооцоолол



## 3-р ХЭСЭГ

- 01 Нүүрсний үнэ 2025 онд 2024 оныхтой ижил түвшинд байх буюу 80.5 сая тонн хүрэх төлөвтэй байна.
- 02 Монголбанкны зүгээс Монгол улсын гадаад валютын албан нөөцийн байх ёстой доод түвшнийг нэг нэгж хувиар ихэсгэсэн.
- 03 Төгрөгийн ханш ирэх онд ойролцоогоор 8 хувиар сулрах хандлагатай байна.
- 04 Монголбанк 2025-2026 онд инфляцын зорилтот түвшнийг  $5\pm 2$  хувьд хадгалан, 2027 онд 5 хувь болгон бууруулах төлөвлөгөө гаргасан.
- 05 Засгийн газрын зардал болон дотоодын эрэлт ихсэхээс гадна эрчим хүчний үнийн нэмэгдэлтэй холбоотойгоор ирэх онд инфляц Монголбанкны тогтоосон зорилтот интервалаас их байна гэж таамаглаж байна.

Ирэх онд Монголын эдийн засгийн өсөлтийн төлөв таатай байгаа хэдий ч эрсдэл байгаа хэвээр байна. Хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахын тулд хөрөнгө оруулагчид эдийн засагт гол нөлөөлөгч хүчин зүйлс болох гадаад валютын албан нөөц, инфляц болон нүүрсний үнийн талаар тогтмол мэдээлэлтэй байх хэрэгтэй. Бидний таамаглалаар гадаад валютын албан нөөцийн хэмжээ өнгөрсөн оноос буурахгүй хадгалагдах, инфляц Монголбанкны тогтоосон зорилтот интервалаас бага зэрэг их байх болон БНХАУ-ын нүүрсний эрэлт хэвээр байх гэсэн эерэг төсөөлөлтэй байна.

### Нүүрсний зах зээлийн үнэ



БНХАУ-аас Австрали улсын нүүрсний экспортод тавьсан хоригийн улмаас Монгол улс нүүрсний томоохон нийлүүлэгчдийн нэг болох боломж бүрдсэн. Хоёр улсын засгийн газрын хамтын ажиллагааны үр дүнд нүүрсний тээвэрлэлтэд тулгараад байсан асуудлуудыг шийдэх ажлуудыг эрчимтэй хэрэгжүүлж эхэлснээр 2025 онд Монгол улсын БНХАУ руу экспортлох нүүрсний дүн хэмжээ 80.5 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

### Гадаад валютын албан нөөц



Монголбанкнаас гадаад валютын албан нөөцийг нэг нэгж хувиар нэмэгдүүлэн 16 хувьд хүргэх шийдвэр гаргасан. Үүний үр дүнд гадаад валютын албан нөөцийн хэмжээ импортын зардалтай харьцах харьцаа нэмэгдэх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч импортын зардлын өсөлттэй холбогдуулан валютын ханш чангарах төлөвтэй байгаагаас үүдэн ам.долларын хөрөнгө оруулалт эрсдэл багатай байх магадлалтай.

### Инфляц



Эрчим хүчний үнийн өсөлтөөс шалтгаалан 2024 оны жилийн эцсээр инфляцын түвшин 8.1 хувьд хүрж өссөн. Мөн засгийн газрын зардлын өсөлттэй холбогдуулан 2025 онд инфляцын түвшин 9-10 хувьд хүрэн тогтворжих төсөөлөлтэй байна. Үүнтэй холбоотойгоор бид 2025 онд тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийг хөрөнгө оруулалтын багцдаа оруулахыг санал болгож байна.

## Нүүрсний зах зээлийн үнэ

Монгол улсын экспортын 80 орчим хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлдэг бөгөөд үүний дийлэнх хэсгийг нүүрсний экспорт бүрдүүлдэг. Эрдэс бүтээгдэхүүний экспортод нүүрсний эзлэх хувь сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байгаа бөгөөд өнгөрсөн хоёр жилд эрчимтэй нэмэгдэн, дунджаар 65 хувийг бүрдүүлсэн байна. Энэхүү өсөлт нь манай улсын гадаад худалдааны гол харилцагч болох БНХАУ-ын нүүрсний эрэлт ихэссэнтэй холбоотой.

Тээвэрлэлттэй холбоотой хилийн боомт дээр тулгардаг байсан асуудлуудыг хоёр улсын хамтын ажиллагааны үр дүнд шийдэж, тээвэрлэлтийн хилийн хяналтын үйл явцыг хялбарчлан, нүүрс зөөх автомашины замыг нэмж барьснаар БНХАУ руу экспортолсон нүүрсний орлого 2023 онд өнгөрсөн онтой харьцуулахад 40 гаруй хувиар ихэссэн дүнтэй байна.

2022 оны 12 дугаар сард “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай” хууль батлагдан, биржийн эрхзүйн орчин бүрдсэнээр 2023 оноос эхлэн тус биржээр дамжуулан эрдэс бүтээгдэхүүнийг амжилттай арилжаалж эхэлсэн.

Энэхүү биржийн үйл ажиллагааг эхлүүлснээр гадаадын худалдан авагчдыг уул уурхайн бүтээгдэхүүнийг шууд худалдан авах боломжийг бүрдүүлсэн юм. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржид бүртгэлтэй 21 компани, 11 уул уурхайн биржийн арилжааны эрхтэй брокерын компаниуд байгаа бөгөөд нийтдээ 19.6 тонн эрдэс бүтээгдэхүүний 450 хэлцлийг амжилттай хийсэн байна.

Биржийн үйл ажиллагаа амжилттай эхэлснээс хойш эхний 8 сарын турш зөвхөн нүүрс арилжаалагдаж байсан бол одоогийн байдлаар төмрийн хүдэр, төмрийн баяжмал, хайлуур жонш болон зэсийн баяжмалыг арилжаалсан байна. Нийт арилжааны дийлэнх буюу 95.5 хувийг нүүрс, 4.1 хувийг төмрийн баяжмал болон хүдэр, 0.3 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол үлдсэн 0.1 хувийг хайлуур жоншны арилжаа бүрдүүлжээ.

Уул уурхайн бирж үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр Монгол улс эрдэс баялгийн бүтээгдэхүүнүүдээ зах зээлийн үнээр зарах боломжтой болж эхэлсэн. Биржийн үйл ажиллагаа нь олон улсын зах зээл дээрх бүтээгдэхүүнүүдийн


үнийн өсөлтийн циклтэй давхцан өмнө нь нэг тонн зэс 70-90 ам.доллараар зарагддаг байсан бол 160-180 ам.доллар болж өссөн дүнтэй байна. 2024 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт экспортлогдсон зэсийн 20 орчим хувь нь тус биржээр дамжин арилжаалагджээ. 2024 оны сүүлийн улиралд л гэхэд ахин 143 дуудлага худалдааны тов зарлагдсан байна. Үүнээс нүүрсний арилжааны дуудах үнэ нь чанараас хамааран 450-1050 юаны хооронд байгаа бол төмрийн хүдрийн дуудах үнэ 56-87 ам.долларын хооронд байна.

БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 2025 онд өнгөрсөн онтой ижил түвшинд байх төлөвтэй байгаа бөгөөд үерээс шалтгаалан усан цахилгаан станцын

үйлдвэрлэл буурсан болон цар тахлын дараагаар эдийн засгаа сэргээх үйл ажиллагаа эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн зэрэгтэй холбоотойгоор 2023 онд тус улсын нүүрсний эрэлт 7 хувиар өссөн дүнтэй байсан юм. БНХАУ сэргээгдэх эрчим хүчний хэрэглээгээ ихэсгэх бодлого баримталж байгаа ч гэсэн ирэх жилүүдэд нүүрс эрчим хүчний гол эх үүсвэр хэвээр байна.

Цар тахлыг дараагаар газны үнэ буурсан болон дэлхий даяар нүүрсний үйлдвэрлэл ихэссэнтэй холбоотойгоор нүүрсний зах зээлийн үнэ 2024 онд 2022 оны үеэс харьцангуй буурсан. Сэргээгдэх эрчим хүч рүү шилжих шилжилтийн хүрээнд нүүрсний үнэ ирэх хоёр жилд жилд дунджаар 8-9 хувь бууран, түүнээс цаашдаа тогтворжих хандлагатай байна.

## 2025 онд нүүрсний үйлдвэрлэл ойролцоогоор 80.5 сая тонн байх тооцоололтой байна.



Хүснэгт 11. Эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэлд суурилсан ДНБ-ийн өсөлтийн төсөөлөл

Эх сурвалж: Шинжээчийн таамаг

2022 онд 2.5 дахин өссөн нүүрсний үйлдвэрлэл ирэх онуудад бага зэрэг бууран, тогтворжих хандлагатай байна. 2024 оны 10 дугаар сард БНХАУ болон Монгол улс удаан хугацааны турш хэлэлцээрийн түвшинд байсан хилийн боомтын дэд бүтцийн асуудлуудыг шийдэх тухай гэрээнд гарын үсгээ зурж баталгаажуулсан. Үүний үр дүнд ирээдүйд хоёр улсын хоорондох гадаад худалдааны хэмжээг 20 тэрбум ам.долларт хүргэнэ гэж амлаад байгаа юм. Монголын нүүрсний экспортын 90 орчим хувийг БНХАУ хүлээж авдаг бөгөөд тус хэлэлцээрээр батлагдсан дэд бүтцийн ажлууд амжилттай хэрэгжсэн тохиолдолд нүүрсний экспорт ирэх жилүүдэд ихээхэн өсөх боломжтой байна.

## Гадаад валютын улсын нөөц


2024 оны 3 дугаар улирлын байдлаар Монголын гадаад валютын улсын нөөц 5 тэрбум ам.долларт хүрж, өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 15 хувиар ихэссэн байна. 2016 онтой харьцуулахад гадаад валютын албан нөөцийн дүн ойролцоогоор 3 дахин өссөн ч импортын зардлыг хангах сарын тоо нь ижил түвшинд байна. 2022 оны 8 дугаар сард Энэ нөөц нь Монгол улсын 5 орчим сарын импортыг хангах хэмжээний буюу 2016 оны үзүүлэлттэй ижил түвшний дүн юм. 2022 оны 8 сард гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал саарч, хилийн хоригоос шалтгаалан экспортын орлого багассантай холбоотойгоор 2.6 тэрбум ам.доллар хүртэл буураад байсан гадаад валютын албан нөөц тухайн үеэс хойш тогтвортой сэргэн 2024 оны эхний улиралд түүхэн дээд хэмжээндээ хүрэн 5 тэрбум ам.долларыг давсан үзүүлэлттэй байна.

2024 оны 12 дугаар сард төгрөгийн ханш сулрах эрсдэлээс сэргийлэн Монголбанкны зүгээс төгрөгийн болон валютын албан нөөцийн доод хэмжээг тус тус 11 болон 16 хувь болгон өсгөсөн.

2025 онд төв банкны зүгээс экспортын орлого нэмэгдэж, Монгол улсын уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэж байгаатай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэн, валютын албан нөөцийн хэмжээ тогтвортой өснө гэсэн хүлээлттэй байна.

БНХАУ-тай хийсэн 7.25 их наяд төгрөг буюу 15 тэрбум юаны валютын своп арилжааны хэлцлийн хугацааг 2023 онд 3 жилээр шинэчлэн сунгасан.

Дээр дурдсан своп арилжааны хэлцэл болон бусад засгийн газрын бондын эргэн төлөлтүүдийн талаарх мэдээллийг цаг тухай бүрд авч байх нь хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахад чухал нөлөөтэй байдаг. Гадаад валютын албан нөөцийг шаардлагатай түвшинд барьж чадсан ч ирэх онд төгрөгийн ханш сулрах хандлагатай байгаа юм.



Хүснэгт 12. Гадаад валютын улсын нөөц болон импортын хэрэгцээг хангах сарын тоо

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

## Инфляц

Монголын эдийн засаг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай байдаг учраас эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн өсөлт бууралтыг дагах хандлагатай байдаг. Өнгөрсөн жилүүдэд Монгол улсын төсөв газрын баялгийн экспортын орлого өсөхөд даган өсөж, түүнийг даган зардал нэмэгдэн, эрдсийн зах зээлийн үнэ унан орлого буурахад зардал мөн адил буурч ирсэн.

Монголбанк 2025-2026 онд инфляцыг  $5 \pm 2$  хувьд хадгалан, 2027 онд 5 хувь болгон бууруулах зорилт тавьсан байна. Гэсэн хэдий ч 2024 оны сүүлийн улиралд эрчим хүчний үнийг огцом өсгөсний нөлөө 2025 оны эхэн үеэс инфляцад нөлөөлөн, өөдрөг төсөөллөөр тус оны инфляц 7-оос багагүй хувьтай байх төлөвтэй байна.

Засгийн газрын зардлын өсөлт болон дотоодын эрэлт ихсэх зэргийн нөлөөгөөр 2025 оны эхний хагаст инфляц Монголбанкны тогтоосон интервалаас их байна гэсэн төсөөлөлтэй байна. 2024 онд валютын ханш харьцангуй тогтворжиж, импортын зардал багассанаар инфляц мэдэгдэхүйц буурч, эдийн засгийг дэмжих зорилгоор тус онд бодлогын хүүг үе шаттайгаар 3 нэгж хувиар бууруулан 10 хувьд хүргэсэн. 2025 онд инфляц өсөх төлөвтэй байгаагаас үзэхэд Монголбанкны зүгээс мөнгөний бодлогын хүүг дахин багасгах магадлал харьцангуй бага байна.

Сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжөөд буй банк бус санхүүгийн байгууллагуудын нөлөөгөөр иргэдийн

өр зээлийн хэмжээ хурдацтай нэмэгдэж, зээлдэгчийн өр орлогын хэмжээ дунджаар 70 орчим хувьд хүрэх нөхцөлийг бүрдүүлжээ. Үүнээс улбаатайгаар дотоодын эрэлт болон иргэдийн зээлийн хэмжээ ирэх онд ч өссөн хэвээрээ байх магадлалтай байна.

2024 оны сонгуулиар үүсгэн байгуулагдсан хамтарсан засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 14 мега төслийн санхүүжилт болон бусад урсгал зардлуудын ихээхэн өсөлттэй холбоотойгоор засгийн газрын зардал ч мөн ирэх онд өсөх хандлагатай байна.



# ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. МӨНГӨНИЙ БОЛОН ТӨСВИЙН БОДЛОГЫН ЗАХ ЗЭЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Бусад газрын баялаг ихтэй орнуудын адилаар Монгол улсын эдийн засгийн өсөлт нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийг дагах хандлагатай байдаг. 2008 онд эрдэс баялгийн бүтээгдэхүүнүүдийн үнэ дунджаар 75 хувь өсөн, зах зээлийн хэт хөөрөгдөлд орох үеийг даган Монгол улсын эдийн засгийн өсөлт 2011 онд түүхэн дээд хэмжээндээ буюу 18 хувьд хүрж, Азийн Саудын Араб ч гэж нэрлэгдээд байсан билээ. Харамсалтай нь Олон Улсын валютын сангийн гаргасан судалгааны дагуу энэ мэт зах зээлийн үнийн хөөрөгдөл нь огцом уналтыг дагуулдаг бөгөөд ихэнх тохиолдолд уг уналтын нөлөө нь өсөлтийн үеийн ашгаас илүү гарзтай байдаг байна. Монгол улсын эдийн засагт ч энэхүү уналт нь тодорхой харагдсан бөгөөд дээрх өсөлтийн үеэс таван жилийн дараа бувуу 2015-2016 онд эдийн засгийн өсөлт 1.5 хувь хүртлээ буурч байжээ. Энэ мэтчилэн эдийн засаг нь нэг салбараас хэт хамааралтай улсуудын хувьд байгалийн баялгийн орлогыг урт хугацаанд захиран зарцуулах тодорхой бөгөөд үр ашигтай төсвийн бодлого, зохицуулалттай байх нь чухал байдаг.

2017 онд Монгол улсын гадаад өрийн дарамт төлж чадахааргүй хэмжээнд хүрэн ихсэж, эдийн засгаа тогтворжуулахын тулд 5.5 тэрбум ам.долларын тусламж авахаас өөр аргагүй байдалд хүрч байсан. Тус тусламжийн хүрээнд Монгол улсын удирдлагууд макро-эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх, тэр дундаа төсвийн тогтвортой байдлыг хангаж ажиллахад онцгой анхаарах амлалт өгч байжээ.

Үүний дагуу 2017-2019 онд төсвийн бодлогод шаардлагатай чухал өөрчлөлтүүдийг хийн өрийн дарамтыг багасгах хүрээнд засгийн газрын зүгээс өндөр хүүтэй гадаад зээлүүдээ эрчимтэй төлж эхэлсэн байна. 2017 онд гэхэд өрийн үндсэн төлөлтийн хэмжээ өмнөх оныхоос хоёр дахин ихэссэн дүнтэй байсан байна. Тэр үеэс эхлэн Монгол улсын засгийн газрын өрийн дарамт мэдэгдэхүйц багасаж, 2024 оны эхний хагас жилийн байдлаар засгийн газрын нийт өрийн ДНБ-тэй харьцуулсан харьцаа нь 77.6 хувьд хүрсэн буюу 2016 онтой харьцуулахад 3 дахин багасжээ.

Сүүлийн жилүүдэд эрдэс бүтээгдэхүүний үнэ огцом өсөж, Монгол улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдээд байга зэрэг нь эдийн засагчдад 2010-2015 оны огцом өсөлт болон уналтын үеийг санагдуулж байна. 2008 онтой харьцуулахад үнийн өсөлт тийм ч хурдацтай биш байгаа ч цар тахлын дараагаар дэлхийн эдийн засаг сэргэж байгаа болон геополитикийн сэргэлдөөнүүдийн улмаас эрдэс баялгийн бүтээгдэхүүнүүдийн үнэ 2022 онтой харьцуулахад 200 орчим хувиар ихэссэн дүнтэй байна.

Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд ихэссэн энэхүү газрын баялгийн ойролцоогоор нэг хувийг л хадгалж байгаа бөгөөд нийгмийн халамж, тэтгэвэр болон төрийн албан хаагчдын цалин гэх мэт нийгмийн зарцуулалтын хэмжээ харьцангуй өсжээ. Нийгмийн халамжийн зардал ийнхүү өссөн хэдий ч Монгол улсын ажиллах хүчний оролцооны түвшин болон хүний хөгжлийн индекс хэвээрээ байгаа буюу тухайн өссөн зардал үр ашиггүй байсан гэж харж болохоор байна.

Монгол улс БНХАУ-ын хилийн хориг болон боомтын үр ашиггүй байдал зэргээс шалтгаалан эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийн эхэн үеийг өнгөрөөсөн. Харин Тавантолгойн төмөр зам болон Оюутолгойн далд уурхайн дэд бүтцийн ажлууд амжилттай хэрэгжиж, уул уурхайн биржийн үйл ажиллагаа явж эхэлснээр Монгол улсын эдийн засаг нэг жилийн дотор маш хурдан өсөж чаджээ.

Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ дахин унах нь гарцаагүй учраас энэхүү газрын баялгийн орлогыг үр ашигтай зарцуулан дэд бүтцээ хөгжүүлэх нь чухал юм. Монгол улсын засгийн газраас 2024 оны эхэнд Ирээдүйн өв сан, Хөгжлийн сан болон Хадгаламжийн сан гэсэн гурван сангаас бүрдсэн Баялгийн сангийн тухай хуулийг баталж хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү сангаар дамжуулан газрын баялгийн орлогыг тэнцвэртэй хуваарилах, ирээдүйн эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаануудыг хийхээр төлөвлөөд байна.

## 5-р ХЭСЭГ

- 01 Монгол улсын засгийн газрын болон компанийн ам.долларын бондууд дунджаар 7, 10 хувийн өгөөжтэй байна.
- 02 2024 онд бодлогын хүүг 3 нэгж хувиар бууруулсантай холбоотойгоор ирэх онд төгрөгийн болон валютын хадгаламжийн хүү буурах магадлалтай.
- 03 Валютын ханшийн тогтворгүй байдал болон хадгаламжийн хүү буурах нөхцлийг харгалзан үзэхэд тогтмол өгөөжтэй ам.долларын хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг хөрөнгө оруулалтын багцдаа багтаахыг санал болгож байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын хөрөнгийн зах зээл хурдацтай өсөж хөгжиж байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 12 их наяд төгрөгийн давж, ДНБ-ийн 17.2 хувьтай тэнцэж байгаа нь сүүлийн 5 жилд 3.5 дахин өссөн үзүүлэлт юм. Энэ хугацаанд арилжааны хэмжээ 4 дахин нэмэгдэж, 1,058.7 тэрбум төгрөгт хүржээ.

Байгуулагдсан цагаасаа хойш хувьцаа, бонд гэсэн хоёр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнтэй байсан хөрөнгийн зах зээлд 2021 онд анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 2024 онд ETF гэх хөрөнгө оруулалтын хэрэгслүүд арилжаалагдаж эхэлсэн. Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүд нэмэгдэж, арилжааны болон институцын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын сонголтуудыг төрөлжүүлж байгаа нь зах зээлийн хөгжлийн гол хөшүүрэг болж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар Монголын хөрөнгийн биржийн арилжааны дийлэнх буюу талаас илүү хувийг компанийн бондын арилжаа эзэлж байгаа бол 23.0 орчим хувийг хувьцааны арилжаа, 12.4 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас үлдсэн 6.1 хувийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа тус тус бүрдүүлж байна.

Энэхүү өсөлтөд иргэд болон байгууллагуудын хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол ихэссэнээс гадна тус салбарын хууль эрхзүйн орчин таатай бүрдсэн, зэрэг нь нөлөөлжээ. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгрөгийн ханш 30 гаруй хувиар суларч, хөрөнгө оруулагчид хадгаламжаас өөр найдвартай бөгөөд өндөр өгөөжтэй боломжуудыг эрэлхийлж эхэлсэн. Өнгөрсөн жилүүдэд төгрөгийн ханш харьцангуй тогтворжсон хэдий ч хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлэх хүсэл хэрэгцээ хэвээр байна.

## **Бодлогын хүү бууруулсантай холбоотойгоор хадгаламжийн хүү багасах төлөвтэй байна.**

Сүүлийн 5 жилд, тэр дундаа цар тахлын үед төгрөгийн ханш огцом суларч, арилжааны банкнуудын хадгаламжийн хүү хангалттай биш хэмжээнд хүрснээр хөрөнгө оруулалтын бусад хэрэгслүүдийн эрэлт эрчимтэй өссөн. Монгол улсын эдийн засгийн уул уурхайн салбараас хэт хамааралтай тогтворгүй байдал, гадаад хүчин зүйлсийн инфляцад үзүүлэх нөлөө зэрэг нь хөрөнгө оруулагчдын энгийн хадгаламжид мөнгөө хадгалах сонирхлыг бууруулж байна. Ам.долларын болон төгрөгийн хугацаатай хадгаламжийн дундаж хүү харилцан 4.0 болон 12.8 хувь байна. 2023 онд

Монголбанк бодлогын хүүгээ шат дараатайгаар 3 нэгж хувиар буулган 10 хувьд хүргэсэн бөгөөд хадгаламжийн хүүгийн хэмжээ үүнийг даган буурахаар байна. 2024 оны сүүлд эрчим хүчний үнийн өсөлтөөс улбаатайгаар улсын инфляц 8.1 хувьд хүрсэн байдалтай байна. Монголбанкны зүгээс ирэх жилд эдийн засгийн өсөлт бууралтын огцом савлагаанаас сэргийлэх үүднээс мөнгөний хатуу бодлого барина гэдгээ мэдэгдсэн. Дээрх үзүүлэлтүүдэд тулгуурлан бид ирэх онд хадгаламжийн хүүг буурах төлөвтэй байна гэж таамаглаж байна.

## **2025 онд ам.долларын бонд нь хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалт болно.**


Сүүлийн жилүүдэд биржийн бус зах зээл нь Монгол улсад хурдацтай хөгжиж байна. 2024 оны эхний хагасын байдлаар биржийн бус зах зээлд 714.7 тэрбум төгрөгийн дүнтэй 62 бонд бүртгүүлсэн нь Монголын хөрөнгийн бирж дээрх бондын татан төвлөрүүлсэн дүнгээс 1.3 дахин их үзүүлэлт юм. Монгол улсад арилжаалагдаж буй нээлттэй болон хаалттай ам.долларын бондын хүү дунджаар 10 орчим хувь, засгийн газрын ам.долларын бондын өгөөж дунджаар 6.9 хувь байгаа нь олон улсад арилжаалагдаж буй ам.долларын тогтмол хүүтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн дундаж өгөөжөөс өндөр байгаа юм. 2025 онд төсвийн зарлага өмнөх онуудтай харьцангуй их нэмэгдэхээр төлөвлөгдсөн байгаа хэдий ч экспортын орлогын өсөлтийн нөлөөгөөр төсвийн

орлого мөн адил нэмэгдэн, төсвийн тэнцэл эерэг байна гэж бид тооцоолсон. Гэсэн хэдий ч импортын зардал мөн адил ихсэн, төгрөгийн ханш сулрах төлөвтэй байгаа учраас ам.долларын хөрөнгө оруулалтын хэрэгслийг хөрөнгө оруулалтын багцдаа оруулах нь өгөөжөө өсгөхөөс гадна ханшийн эрсдэлээс сэргийлэх оновчтой шийдвэр болох юм. Олон улсын байгууллагуудаас Монгол улсын зээлжих зэрэглэлийг өсгөн В+ болгосон нь арилжааны банкнуудад олон улсад ам.долларын бонд гаргахад түлхэц болж өгч байна. 2024 онд стратегийн хоёр банк ам.долларын өрийн хэрэгслийг олон нийтэд амжилттай санал болгоод байгаа бөгөөд ирэх онд ч энэ тренд үргэлжлэх төлөвтэй байна.



Figure 13. Interest and coupon rates of alternative investment instruments in US dollar

In the last couple years, in addition to the government bonds, companies in the private sector have successfully issued bonds in US dollar, promising higher than average coupon rates of around 10 percent in the open exchange, and 10.3 percent on average for over-the-counter exchange.




## Төгрөгийн бонд нь хөрөнгө оруулагчдад өндөр өгөөж амлахаас гадна хөрөнгө оруулалтын багцын хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлж байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор 2014 оноос Монгол улсын засгийн газрын бондыг Монголын хөрөнгийн биржээр арилжаалж эхэлсэн байдаг. Засгийн газрын бонд нь татвараас чөлөөлөгдөхөөс гадна эрсдэлгүй хөрөнгө оруулалт болдог учраас хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхтэй арилжаалагддаг үнэт цааснуудын нэг байжээ. Ийнхүү хөрөнгө оруулагчид өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж эхэлснээр аж ахуйн нэгжүүд бонд гаргах замаар санхүүжилт татах боломжтой болгосон байна. Эхэн үедээ хөрөнгө оруулагчдын дийлэнх нь хувь хүн буюу харьцангуй бага дүнгээр богино хугацаанд арилжаа хийх сонирхолтой байснаас компанийн өрийн хэрэгслүүд эргэн төлөлтийн хугацаагаа урт байлгах боломжгүй байсан. Сүүлийн гурван жилд биржийн бус зах зээл хурдацтай хөгжин, түүнийг дагасан мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон үнэт цаас гаргагчид таатай хууль эрхзүйн бүрдсэнээр өрийн хэрэгсэл гаргах компанийн тоо нэмэгдэн, арилжааны дүн, идэвх улам бүр нэмэгдсээр байна. 2024 оны сүүлийн байдлаар биржийн бус зах зээлд 16-20 хувийн өгөөжтэй 60 гаруй компанийн бонд

идэвхтэй байгаа бол Монголын хөрөнгийн бирж дээр дунджаар 17.4 хувийн хүүтэй, 12-36 сарын хугацаатай 8 бонд нээлттэй арилжаалагдаж байна.

2024 онд Олон улсын санхүүгийн корпорацаас анх удаа төгрөгийн бонд гаргасан нь олон улсын хөрөнгө оруулагчдыг төгрөгийн бондод хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болсон юм. 2023 оны эдийн засгийн үсрэнгүй хөгжил ирэх жилүүдэд ч үргэлжлэх төлөвтэй байгаа нь хөрөнгө оруулагчдыг татах гол хүчин зүйл болж байсан бол энэхүү бонд гарснаараа төгрөгийн эрэлтийг өсгөхөөс гадна төгрөгийн хөрөнгө оруулалтыг олон улсад танилцуулах гарц болж байна.

Одоогоор арилжаалагдаж буй төгрөгийн бондуудын дундаж өгөөж нь харьцангуй өндөр байгаагаас гадна дээр дурдсанаар төгрөгийн бондод хөрөнгө оруулах сонирхол сүүлийн жилүүдэд тогтвортой нэмэгдэж байгаа нь өрийн хэрэгслийн хөрвөх чадварыг сайжруулж, зах зээлийн үнийн савлагааны эрсдэлээс сэргийлж байна.



Хүснэгт 14. Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн арилжааны үнийн дүн

Өнгөрсөн арван жилийн хугацаанд хөрөнгө оруулагчдын нэмэгдсэн болон хууль эрхзүйн орчин тогтворжисны нөлөөгөөр бондын зах зээл хурдацтай хөгжсөн. Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдын зүгээс тус зах зээлийн тулгарч байгаа асуудлуудыг зохицуулан шийдвэрлэх идэвхтэй хичээл зүтгэл гаргаж байгаагаас харахад ирэх жилүүдэд ч бондын зах зээл улам хөгжих төлөвтэй байна.

Бидний үзэж байгаагаар ам.доллар болон төгрөгийн тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүд нь ойрын ирээдүйд эрсдэл багатай бөгөөд өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэх боломжийг олгож байна. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулагчид шийдвэр гаргах бүрдээ түүхэн үзүүлэлтүүд ирээдүйн баталгаа болж чадахгүйг санан, өөрийн дааж чадах эрсдэлийг шинжилж байх нь чухал юм. Энэхүү тайлан нь эдийн засгийн индикаторуудын өнгөрсөн үзүүлэлтэд тулгуурлан, ойрын хугацаанд болзошгүй хөрөнгө оруулалтын боломжууд, эрсдэлүүд дээр суурилсан учраас ямар нэгэн тухайлсан хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш, ерөнхий мэдээллийн чанартайг харгалзан үзнэ үү.